

БАТЛАВ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

БАТЛАВ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

З.МЭНДСАЙХАН

Х.НЯМБААТАР

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2-т дэвшүүлсэн эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэх зорилтыг “хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх”¹ болон “хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хэрэглээг хязгаарлах”² замаар хэрэгжүүлэхээр тусгасан.

Монгол Улсад 2019 онд архины 35, спиртийн 8, шар айрагны 17, дарсны 8, нийт 68 үйлдвэр байгаа нь 2012 онд зөвхөн архины 75 үйлдвэр ажиллаж байсантай харьцуулахад 50 гаруй хувиар буурсан үзүүлэлтэй байгаа боловч Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан мэдээгээр улсын хэмжээнд 2012 онд 26881.7 мянган литр архи дарс, 65124.6 мянган литр шар айраг үйлдвэрлэсэн бол 2019 онд 27155.5 мянган литр архи, 91975.1 мянган литр шар айраг үйлдвэрлэж³, нэг хүнд ногдох согтууруулах ундааны хэмжээ 2012 оны байдлаар 32.8 литр байсан нь 2019 онд 37.2 литр болж нэмэгдсэн⁴ байгаа нь хэдийгээр согтууруулах ундааны үйлдвэрийн тоо цөөрсөн үзүүлэлттэй байгаа боловч согтууруулах ундааны үйлдвэрлэл, хэрэглээ өсөлттэй байгааг илтгэж байна.

2003 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн 19934 гэмт хэргийн 3842 нь, 2010 онд бүртгэгдсэн 19825 гэмт хэргийн 4610 нь, 2019 онд 31524 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 4371 нь согтуугаар үйлдэгдсэн⁵ байна. Цагдаагийн байгууллагын харьяалалд ажилладаг эрүүлжүүлэх байранд улсын хэмжээнд 2016 онд 87356 хүнийг албадан эрүүлжүүлсэн бол 2019 оны байдлаар 111076 хүн, тэдгээрийн 92 хувь нь эрэгтэй, 7.8 хувь нь эмэгтэй, 0.2 хувь нь 18 хүртлэх насны хүмүүс байсан байна⁶. Үүнээс дүгнэхэд архи, согтууруулах ундааны хэрэглээг багасгах талаар ямар нэгэн ахиц,

¹ “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 20212030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа” Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт 2.2.8 дахь заалт.

² “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 20212030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа” Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт 2.2.9 дэх заалт.

³ Үндэсний статистикийн хорооны “Аж үйлдвэрийн салбарын гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл” судалгаа, https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSQ_1100_013V1&AJ01_select_all=0&AJ01SingleSelect= 52_53&YearY_select_all=0&YearYSingleSelect=&viewtype=table

⁴ Үндэсний статистикийн хорооны “Нэг хүнд ногдох аж үйлдвэрийн зарим нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл” судалгаа, https://1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSQ_1100_008V1&CPC_AY1_select_all=0&CPC_AY1SingleSelect=&YearY_select_all=0&YearYSingleSelect=&viewtype=table

⁵ Цагдаагийн ерөнхий газрын Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал 2019 он, 74 дэх тал

⁶ Цагдаагийн ерөнхий газрын Монгол улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал 2019 он, 9 дэх тал

дэвшил гараагүй төдийгүй архидан согтуурах явдал нь гэмт хэрэг, зөрчилд холбогдох гол шалтгаан нөхцлийн нэг хэвээр байгааг харуулж байна.

2012 онд архинд донтох өвчний улмаас 710 хүн эмчлүүлснээс 485 нь анх удаа, 225 нь давтан эмчилгээ хийлгэж⁷ байсан бол Согтуурах, мансуурах донтой хүнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөрлүүлэх газраас гаргасан мэдээгээр 2019 онд 883 хүн албадан эмчилгээ хийлгэснээс 18-28 насны 28 хүн, 29-61 насны 851 хүн, 62 дээш насны 4 хүн тэдгээрийн 637 нь анх удаа, 246 нь давтан эмчлүүлсэн байна. 2020 оны 8 дугаар сарын байдлаар 607 хүн архинд донтох өвчний улмаас албадан эмчилгээнд хамрагдснаас 409 хүн анх удаа, 198 хүн давтан эмчлүүлснээс 28 нь 18-28 насны, 578 нь 29-59 насны хүмүүс байсан байна. Архинд донтох өвчинд хөдөлмөрийн насны хүмүүс илүү өртөж байгаа тул архинд донтох өвчний хор уршигтай тэмцэхэд эмчилгээ үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эмчилгээний хугацааг уртасгаж чанарыг сайжруулах шаардлага тулгараад байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль өнөөг хүртэл мөрдөгдөхдөө нийт 12 удаа нэмэлт, өөрчлөлт орж байсан боловч нэг хүнд ногдох согтууруулах ундааны хэмжээ, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн тоо, согтууруулах ундааны нийгэмд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөлд мэдэгдэхүйц өөрчлөлт гарахгүй байгаа нь тус хуулийн зохицуулалт бодит байдалтай нийцээгүй, нийгмийн харилцааны өөрчлөлт, хөгжлөөс хоцорсон, зайлшгүй зохицуулах ёстой харилцааг хамарч зохицуулаагүй зэрэг учир дутагдалтай байгааг илтгэж байна.

Түүнчлэн архидан согтуурах явдалтай тэмцэх тэмцлийг үр дүнтэй болгох ямар арга хэмжээ авах шаардлагатай талаар санал асуулга явуулахад 8% нь архидан согтуурах явдлын эсрэг төр засгийн зүгээс үр дүнтэй иж бүрэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, 6 % нь архинд донтох өвчтэй хүмүүсийн сэтгэхүйг эрүүл болгох, 12% нь архи хэрэглэх ёс, зан заншлыг ард иргэдэд хүртээмжтэй өргөнөөр сурталчлан, ухуулан ойлгуулах, 22% нь хуулийн хариуцлагыг чангатгах, 15% нь ажилгүйдэл ядуурлыг бууруулах, 15% нь архи согтууруулах ундааг худалдан борлуулах цэг салбарыг цөөлөх, архины үйлдвэрлэл, **экспортөөр импортоор** оруулж ирэх архи согтууруулах ундааны хэмжээг багасгах, 18% нь архидан согтуурах явдалтай тэмцэх хууль тогтоомжийг боловсронгуй болгох, 4% нь архигүй орчин бүрдүүлэх гэж тус тус хариулсан байна.

Иймд дээр дурдсан бодлогын баримт бичигт туссан зорилтыг биелүүлэх, согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй үр дагаврыг арилгах хэрэгцээ шаардлагад үндэслэн согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахаас үүдэлтэй эрсдлийг бууруулах ажлыг үр дүнтэй, оновчтой зохион байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага үүссэн гэж үзэж байна.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа

Хуулийн төсөлд дараах асуудлыг тусгаж зохицуулна. Үүнд:

1.Хуулийн төсөлд согтууруулах ундаа үйлдвэрлэх, импортлох тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэх, сэргээх журмыг тодорхой тусгаж, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн хийдлийг арилгах, тусгай зөвшөөрөл

⁷ Согтуурах,мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан 2017 он, 4дэх тал

олгох сонгон шалгаруулалт явуулах журмыг Засгийн газар батлах, тусгай зөвшөөрлийг тухайн тусгай зөвшөөрлийг эзэмшиж байгаа хуулийн этгээдийг өөрчлөх арга замаар бусдад шилжүүлэх явдалд хяналт тавих зохицуулалтыг тусгана.

2.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг улсын хэмжээнд нэгдмэл байдлаар Засгийн газар баталдаг байх, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх цэгийн тоо, нормативыг хуульчлах, нутгийн өөрөө удирдах байгууллагад энэ талаар зарим эрхийг олгох эсэх асуудлыг судалж шийдвэрлэнэ.

3.Согтууруулах ундааны үйлдвэрлэлд орчин үеийн шаардлагад нийцсэн, өртөг зардал багатай, өдөр тутмын үйлдвэрлэл, борлуулалтын мэдээллийг эрх бүхий байгууллагад онлайн хэлбэрээр дамжуулах, үйлдвэрлэлд зайнаас хяналт тавих боломж бүхий нэгдсэн сүлжээ, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх эрх зүйн орчныг бий болгоно. Ингэснээр согтууруулах ундааны үйлдвэрлэлд ашиглаж байгаа тоолуурын талаархи эрх зүйн орчин тодорхой болж, төрийн байгууллагын үүрэг, оролцоо, тоолуурын үзлэг, шалгалт, ашиглалтын талаархи харилцаа зохицуулалттай болно.

4.Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны төрөл, зэрэглэлийг тогтоож, тэдгээрийн онцлогт тохируулан үйл ажиллагаа явуулах, согтууруулах ундаагаар үйлчлэх цагийн хуваарийг ялгамжтайгаар тогтооно.

5.Согтууруулах ундааг худалдаалах, түүгээр үйлчлэх цагийг хуульчлан тогтоох, ингэхдээ нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага хуульд заасантай уялдуулан хориглолт, хязгаарлалтыг нэмж тогтоох эрхтэй байх, түр хугацааны, эсхүл нэг удаагийн шинжтэй арга хэмжээний үед согтууруулах ундаагаар үйлчлэх түр зөвшөөрөл олгож болох, түүнийг олгох журмыг тусгана.

6.Согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх цэгүүдийн нягтаршлыг бууруулах үүднээс согтууруулах ундаа худалдаалах, үйлчлэх цэгийн тоог тухайн нутаг дэвсгэрт оршин сууж байгаа хүн амын тоо, бусад үзүүлэлтийг харгалзан тогтоох, согтууруулах ундааны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тухайлан зааж хориглосон зохицуулалт оруулна.

7.Баар, цэнгээний газруудад “согтууруулах ундаагаар хариуцлагатай үйлчлэх хөтөлбөр”-ийг бий болгох, согтууруулах ундаагаар үйлчлэх аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд, тэдгээрийн ажилчдыг уг хөтөлбөрт заавал хамрагдсан байх шаардлагыг хуульчилна.

8.Гудамж талбай зэрэг олон нийтийн зарим газруудад согтууруулах ундааны зүйл хэрэглэх, нийтэд ил тод, нээлттэй барьж явах, лац, ломбо, баглаа, боодлыг нь хөндсөн байдалтай авч явахыг хориглох, хууль зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлнэ.

9.Согтууруулах ундааны хэрэглээг бууруулах зорилгоор савлагааны доод, дээд хэмжээг хуульчилна. Тухайлбал,согтууруулах ундааг жижгээр буюу 100 грамм, 50 граммаар савлахыг хориглож, үйлчилгээний газарт шар айргийг 0,33 литрийн савалгаатайгаар борлуулдаг байхаар зохицуулна. Мөн үйлчилгээнд хэрэглэх хундага, бусад хэрэгслийн стандартыг тогтоож мөрдүүлэх зэрэг хэрэглээг багасгах зорилго бүхий бусад арга хэмжээний талаар тусгана.

10.Согтууруулах ундааны хэрэглээ, түүний хор хөнөөлийг судлах үндэсний хэмжээний мониторинг, хяналт, согтууруулах ундааны үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол шалгадаг механизмыг бий болгоно.

Хуулийн нэрийг Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай гэж өөрчлөнө.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэх эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар согтууруулах ундааны үйлдвэрлэл, импорт, худалдаа, үйлчилгээ болон хэрэглээ, архидан согтууралтаас үүдэлтэй сөрөг үр дагавраас хүн амыг хамгаалах, согтуурах донтой этгээдийг эмчлэх, нийгэмшүүлэх зорилго бүхий архидан согтууралттай хийх тэмцэл эрх зүйн хувьд тодорхой болж, энэхүү асуудалтай холбоотой үйл ажиллагаа явуулдаг төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хоорондын эрх, үүргийн зохицуулалт нэг мөр болно.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байх бөгөөд уг хуулийн төсөлтэй уялдуулан Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Чөлөөт бүсийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онцгой албан татварын тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын төслүүдийг боловсруулна.